**2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ**

**2022.02.14.** **Дугаар 20**

| № | ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ТОВЧ АГУУЛГА | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН | БИЕЛҮҮЛЭХ ХУГАЦАА | БИЕЛЭЛТ |
|---|---|---|---|---|
| 1 | Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага болон орон сууцанд амьдардаг айл, өрхүүдийн нэгдсэн халаалтын түгээлтийн чанарт шалгалт хийх ажлын хэсэг ажиллуулах, дүгнэлт гаргах. | Аймгийн МХГ<br>Аймгийн ОБГ<br>Аймгийн ГХБХБГ | II/17 | Гомдлын дагуу шалгах комиссын бүрэлдэхүүнд дулаан хэмжих багажтайгаа мэргэжилтнийг томилсон. |
| 2 | Аймгийн Цагдаагийн газрын байрны 3 давхрын өргөтгөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гадаадын иргэн, харьяатын газрын шинэ барилгын зураг, төсвийг бэлэн болгох, газрын асуудлыг шийдвэрлэх. | ГХБХБГ-ын дарга К.Болат | II/17 | Аймгийн Цагдаагийн газраас барилгын асуудлаар ямар нэгэн хүсэлт ирээгүй. Харин Гадаадын иргэн, харьяатын газрын асуудал хуучин барилгын сууринд дээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2321м2 газрын асуудлыг шийдвэрлэсэн. |
| 3 | E-Mongolia платформын хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийг оролцуулан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн ажлыг сурталчлах өдөрлөг зохион байгуулах, дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулах. | Аймгийн ГХБХБГ<br>Аймгийн УБХ<br>Аймгийн НДХ<br>Аймгийн ЭМДХ | II/17 | Egazar.gov.mn Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийг байнга сурталчлан сургалт явуулж, гарын авлага бэлдэж үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд тарааж, зөвлөгөө өгч ажиллаж байна. Харин сумын даамлуудыг тухайн сумand E-Mongolia хариуцсан мэргэжилтэнтэй холбон хамтран ажиллуулж байгаа. |
| 4 | Байгууллага болгон хүний нөөцийн төлөвлөлт, томилгоонд хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан, илэрсэн зөрчил дутагдлыг нэн даруй засах арга хэмжээ авах. ТАЗ-ийн 411 | Нийт байгууллага, агентлаг | II/17 | ТАЗ-ийн 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, түр буюу сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон ажилтнуудыг нэн даруй чөлөөлөх арга хэмжээ авах. | | | |
| 5 | Хөрөнгө орлогын мэдүүлэг баталгаажуулаагүй ЭБАТ, мэдүүлэг гаргаагүй албан тушаалтны мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдөрт багтаан гаргуулах, баталгаажуулах. | Нийт байгууллага, агентлаг | II/17 | Байгууллагын 5 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг баталгаажуулсан. |
| 6 | Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дугаартай захирамжийн биелэлт хангалтгүй, буруу албан даалгаварын биелэлтийг гаргаж, ирүүлсэн байх тул биелэлтийн тайланг дахин гаргаж, аймгийн ЗДТГ-т бичгээр ирүүлэх. | Нийт байгууллага, агентлаг | II/17 | Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дугаартай захирамжийн биелэлтийг аймгийн ЗДТГ-т албан тоотоор хүргүүлсэн. |
| 7 | АТГ-аас байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлтөд үнэлгээ хийх болсон тул мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг зохих ёсоор байршуулах, олон нийтэд хүргэж, хяналтын ажлын хэсэгт хамтран ажиллах. | Нийт байгууллага, агентлаг | II/17 | Мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд 1-р сарын мэдээллийг бүрэн оруулсан. |
| 8 | Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-т ирүүлэх. | Нийт байгууллага, агентлаг | II/17 | Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-т 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 77 тоотоор хүргүүлсэн. |

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР